



МОНГОЛ УЛС  
АРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 02 сарын 13 өдөр

Дугаар 2/39

Эрдэнэбулган сум

Шуурхай штаб байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2020 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн 10 дугаар зарлиг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсэг, Засгийн газрын 30, 62 дугаар тогтоол, Улсын онцгой комиссын 2020 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 04 дүгээр тушаал, 2020 оны 01, 02, 03, 04 дүгээр хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Шинэ коронавирусийн дэгдэлт дэлхийн улс орнуудад хурдтай тархаж байгаатай холбогдуулан шуурхай штабыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга:	Б.Болормаа	Аймгийн Засаг даргын орлогч
Нарийн бичгийн дарга:	Д.Эрдэнэбаатар	Онцгой байдлын газрын дарга, хурандаа
Гишүүд:	Д.Цэрэннадмид	Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга
	Ж.Мөнхбат	Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
	П.Энхтайван	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга
	Ш.Гомбодорж	Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга
	И.Амартүвшин	Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
	Ж.Гурвантамир	Эрдэнэбулган сумын Засаг дарга
	Ж.Ганбаатар	Цэргийн штабын дарга
	Ё.Дандарванчиг	Ус цаг уур орчны шинжилгээний төвийн дарга
	Р.Гандиймаа	Эрүүл мэндийн газрын дарга
	П.Гомбодорж	Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга
	Ц.Мөнхбат	Боловсрол, Соёл урлагийн газрын дарга
	Т.Цогтбаатар	Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн Архангай аймаг дахь салбарын дарга
	Э.Золбаатар	Цагдаагийн газрын дарга
	Ө.Батхүү	Мэдээлэл холбоо сүлжээ ТӨХК-ийн дарга
	Б.Түмэнжаргал	Авто тээврийн төвийн дарга
	Н.Мөнхбаяр	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга
	Н.Цэвэгдорж	Мэргэжлийн хяналтын газрын дарга

Н.Баянмөнх Байгаль орчин аялал жуулчлалын газрын дарга

Д.Амарбаясгалан Мал эмнэлгийн газрын дарга

Т.Ганбаатар Ар-Ус Ундарга ХХК-ийн захирал

Д.Мөнхбат Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын дарга

Т.Сүхбаатар Улаан загалмайн хорооны дарга

2. Монгол Улсын Ерөнхийлөгчийн Зарлиг, Засгийн газрын тогтоол, Улсын Онцгой комиссын шийдвэр, аймгийн Засаг даргын захирамж, албан даалгаврын хэрэгжилтийг хангуулж, шинэ коронавирусээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх, удирдлагаар хангаж, хяналт тавьж ажиллахыг Шуурхай штабын дарга /Б.Болормаа/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХНАСАН



МОНГОЛ УЛС  
АРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 02 сарын 13 өдөр

Дугаар А/38

Эрдэнэбулган сум

Шинэ коронавирусын болзошгүй аюулаас  
урьдчилан сэргийлэх зарим  
арга хэмжээ авах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2020 оны 02 дугаар сарын 12-ний өдрийн 10 дугаар зарлиг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн хуулийн 32 дугаар зүйлийн 32.1, Засгийн газрын 30, 62 дугаар тогтоол, Улсын онцгой Комиссын 2020 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 04 дүгээр тушаал, 2020 оны 01, 02, 03, 04 дүгээр хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Шинэ коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх, эрсдлийг бууруулах зорилгоор Цагаан сарын баярыг нийтээр тэмдэглэхийг хориглосугай.

2. Баар, караоке, кафе, бүх төрлийн сүм хийдийн үйл ажиллагааг түр зогсоосугай.

3. Хүнсний дэлгүүр, зоогийн газрын согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх цагийн хуваарийг 10:00-17:00 цаг хүртэл тогтоосугай.

4. Аймгийн Архивын лавлагааг түр хугацаагаар зогсоосугай.

5. Эрүүл ахуйн тухай хуулийн 20.1.4 - д заасны дагуу Нийтийн эзэмшлийн зам талбай, зах орчмын зөвшөөрөгдсөнөөс бусад цэгт гар дээрээс болон тээврийн хэрэгсэл дээр хүнсний бүтээгдэхүүнийг ил задгай худалдаалах үйлчилгээ эрхлэхийг хориглосугай.

6. Шинэ коронавирусийн (2019-nCoV) халдвараас урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөөг цаг үеийн байдалд тохируулан шинэчлэн боловсруулж ажиллахыг Эрүүл мэндийн газрын дарга /Р.Гандиймаа/-д үүрэг болгосугай.

7. Аймгийн Засаг даргын 2020 оны А/22, А/44 дүгээр захирамж, 01, 02 дугаар албан даалгаврын хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллахыг сумдын Засаг дарга, төрийн болон хувийн хэвшлийн байгууллага, аж ахуйн нэгжийн дарга, захирал нарт үүрэг болгосугай.

8. Шинэ коронавирусийн халдвар болон Олон улсын эрүүл мэндийн дүрмээр зохицуулагддаг бусад халдварт өвчний эрсдлээс урьдчилан сэргийлэх үүднээс гудамж зам талбай, нийтийн эзэмшлийн болон үйлчилгээний газар, орон сууцны орчны газарт нус, цэр шүлсээ хаяхгүй байх, ил задгай бие засах, хог хаягдлаар орчноо бохирдуулахгүй байх үүргээ биелүүлэхийг аймгийн иргэн бүрт уриалсугай.

9. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч /Б.Болормаа/, Онцгой байдлын газрын дарга /хур Д.Эрдэнэбаатар/ нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.МӨНХНАСАН



МОНГОЛ УЛС  
АРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
АЛБАН ДААЛГАВАР

2020 оны 02 сарын 13 өдөр

Дугаар 02.

Цэцэрлэг

Шинэ коронавирусийн болзошгүй эрсдэлээс  
урьдчилан сэргийлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2020 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн 10 дугаар зарлиг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн хуулийн 32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсэг, Засгийн газрын 30, 62 дугаар тогтоол, Улсын онцгой Комиссын 2020 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 04 дүгээр тушаал, 2020 оны 01, 02, 03, 04 дүгээр хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ДААЛГАХ нь:

**Сумдын Засаг дарга нарт:**

1. Харьяа нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн байгууллагуудын болзошгүй эрсдэлийн үед шаардлагатай хүний нөөц, эм, эмнэлгийн хэрэгсэл, багаж тоног төхөөрөмж, ариутгал, халдваргүйтгэлийн бодис, хамгаалах хувцас хэрэгсэл, амны хаалт, урвалж оношлуур, дэлгэх орны нөөцийг нэмэгдүүлж, бэлэн байдлыг хангах;
2. Ресторан, зоогийн газар, цайны газрын үйл ажиллагааг 18:00 цаг хүртэл ажиллуулах, нэг таваг болон тогооноос олуулаа иддэг нэрийн хоолыг тухайн хугацаанд түр хориглох;
3. Зочид буудлын үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж, буудалласан иргэний дэлгэрэнгүй бүртгэл судалгааг үнэн зөв бүртгэх;
4. Согтууруулах ундаагаар үйлчлэх караоке, баар бүх төрлийн сүм хийдийн, үйл ажиллагааг түр зогсоох;
5. Байгууллагын болон нийтийн эзэмшлийн зам, талбайд ариутгал халдваргүйтгэлийн ажлыг зохион байгуулах;
6. Тэнэмэл нохой, муур устгах ажлыг зохион байгуулах;
7. Архивын тасгаас иргэдэд олгох ажилласан жилийн лавлагаа үйлчилгээг түр хугацаагаар зогсоосон талаар иргэдэд мэдээлэх;
8. Аж ахуйн нэгж, байгууллагаас гарч байгаа албан бичгийг эх хувиар хүргүүлэхээс бусад тохиолдолд цахим сүлжээгээр хүргүүлэх;
9. Архи, согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрөлтэй хүнсний дэлгүүрийн согтууруулах ундаа худалдах цагийг 10:00 - 17:00 цаг болгож, үйл ажиллагааг 22:00 цаг хүртэл ажиллуулах;
10. Шагнал гардуулах ёслолын арга хэмжээ зохион байгуулахыг түр хугацаанд хориглох;
11. Малчид, иргэдийн хөдөлгөөнийг хязгаарлах, өөр сум орон нутагт зорчуулахгүй байх, бүртгэл хөтөлж, хяналт тавих



12. Эрдэнэбулган сумын 7 дугаар багийн төвийг Өрхийн эрүүл мэндийн төвийн байрнаас гаргаж, халдварт өвчний сэжигтэй тохиолдлыг тусгаарлах нөхцлийг бүрдүүлэх;

13. Аймгийн Засаг даргын зөвшөөрөлгүйгээр Улаанбаатар, хөдөө орон нутагт явахгүй байх;

#### **Эрүүл мэндийн газарт:**

1. Бүх шатны эрүүл мэндийн байгууллагуудад болзошгүй эрсдэлийн үед шаардлагатай хүний нөөц, эм, эмнэлгийн хэрэгсэл, багаж тоног төхөөрөмж, ариутгал, халдваргүйтгэлийн бодис, хамгаалах хувцас хэрэгсэл, амны хаалт, урвалж оношлуур, дэлгэх орны нөөцийг нэмэгдүүлж, бэлэн байдлыг хангах;

2. Эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтнуудын халдвар хамгааллын аюулгүй байдлыг бүрэн хангах;

3. Бүх шатны эрүүл мэндийн байгууллагуудын эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтнуудын мэдлэгийг дээшлүүлэх;

4. Хот хоорондын зорчигч тээврийн автобусаар ирж байгаа зорчигчдын халууныг үзэж, хяналт тавих;

5. Сэжигтэй тохиолдлын дуудлагад шуурхай хариу арга хэмжээ авах;

6. Шинэ коронавирүсийн халдварын талаар иргэдийг үнэн зөв мэдээллээр хангах;

7. Шинэ короавирүсийн халдвараас урьдчилан сэргийлэх ариутгал, халдваргүйтгэлийг албан байгууллага, аж ахуйн нэгжүүдэд гэрээний дагуу ариутгал халдваргүйтгэл, шавжгүйтгэл хийх тусгай зөвшөөрөл бүхий аж ахуй нэгж, байгууллагаар хийлгэх;

8. Шинэ коронавирүсийн (2019-nCoV) халдвараас урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөөг цаг үеийн байдалд тохируулан шинэчлэн боловсруулах

#### **Боловсрол соёл урлагийн газарт:**

1. Хот хоорондын зорчигч тээврийн автобусаар ирж байгаа зорчигчдын халууныг үзэж, хянах үйл ажиллагаанд Ерөнхий боловсролын сургуулийн эмч нарыг дайчлан ажиллуулах;

2. Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын үдийн цай, цэцэрлэгийн хүүхдийн хоолны хэмнэгдсэн зардлыг урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгаа, халдвар хамгааллын үйл ажиллагаанд зарцуулах;

3. Сэжигтэй тохиолдлуудын хавьтлуудыг тусгаарлах байрыг аймгийн Багшийн сургуулийн дотуур байранд бэлтгэж, бэлэн байдлыг хангах;

#### **Мэргэжлийн хяналтын газарт:**

1. Нэг таваг болон тогооноос олуулаа иддэг нэрийн хоолыг тухайн хугацаанд хориглох;

2. Нийтийн худалдааны төв, үйлчилгээний газрууд, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжүүдийн цэвэрлэгээ, халдваргүйтгэлийн үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж зөвлөмжөөр хангах;

3. Албан хаагчдын халдвар хамгааллын хувцас хэрэглэл, бэлэн байдлыг хангаж ажиллах;

#### **Цагдаагийн газарт:**

1. Цагаан сарын үеэр иргэдийг хаалганаас хаалганд шилжих хөдөлгөөнд хяналт тавих;

2. Албан хаагчдын халдвар хамгааллын хувцас хэрэглэл, бэлэн байдлыг хангаж ажиллах;

3. Аймгийн орон нутгийн зам дагуу байрлаж байгаа постоор дайран өнгөрөх зорчигч, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хяналт тавих;

4. Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл цахим орчинд баталгаажуулахгүй худал ташаа мэдээллийг тараасан иргэн, хуулийн этгээдэд хууль журмын дагуу хариуцлага хүлээлгэх;

5. Аймгийн Засаг даргын захирамж, албан даалгаврын биелэлтэд хяналт тавьж ажиллах.

#### **Авто тээврийн төвд:**

1. Аймгийн төвийг дайран өнгөрч байгаа хот хоорондын зорчигч тээврийн автобусыг аймгийн төвд түр зогсоход бүртгэлжүүлэн үзлэг зохион байгуулж нэвтрүүлэх;

2. Автобусанд сэжигтэй тохиолдол илэрсэн үед хавьтлуудыг түр тусгаарлах байрыг бэлтгэх.

#### **Тагнуулын хэлтэст:**

1. Өвчлөл бүртгэгдсэн улс орноос 2020 оны 01 дүгээр сарын 15-ны өдрөөс хойш ирсэн иргэдийн бүртгэл, судалгааг гаргах.

#### **Төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудад:**

1. Эрүүл мэндийн газраас өгсөн зөвлөмжийн дагуу цэвэрлэгээ, халдваргүйтгэлийг өдөр бүр хийх;

2. Байгууллагын ажилчдыг Шинэ коронавирусээс урьдчилан сэргийлэх, мэдээллээр хангах;

3. Үйлчлүүлэгч болон албан хаагчдынхаа амны хаалт хэрэглэх, гар угаах, ундны халуун цэвэр усаар хангах, нөхцөлийг бүрдүүлэн ажиллах;

4. Байгууллагын дотоод орчны цэвэрлэгээ, агаар сэлгэлт, ариутгал халдваргүйтгэлийг өдөрт 3-аас доошгүй удаа тогтмол хийж хэвшүүлэх;

5. Байгууллагын ажилтны гэр бүлийн гишүүн өвдсөн асаргаа шаардлагатай тохиолдолд эмчийн магадалгааг үндэслэн 5 хүртэлх хоногийн цалинтай чөлөө олгож дэмжиж ажиллах;

6. Аймгийн Засаг даргын зөвшөөрөлгүйгээр Улаанбаатар хот, хөдөө орон нутагт явахгүй байх;

7. Банк санхүүгийн байгууллага болон АТМ байрлуулсан байгууллага аж ахуйн нэгжид чийгтэй цэвэрлэгээ тогтмол хийж хэвших;

8. Байгууллагын нэгдсэн золголт хийхгүй байх;

9. Эцэг эхийн үүрэг хариуцлагаа ухамсарлаж хүүхдээ өөрсдийн хараа хяналтад байлгах, сонор сэрэмжтэй байж аливаа болзошгүй аюул эрсдэлээс урьдчилан сэргийлэх, гэр бүлээ хамгаалах талаар мэдээллээр хангах;

10. Шагнал гардуулах ёслолын арга хэмжээ зохион байгуулахыг түр хугацаанд хориглох;

11. Аж ахуй нэгж, байгууллагаас гарч байгаа албан бичгийг эх хувиар хүргүүлэхээс бусад тохиолдолд цахим сүлжээгээр хүргүүлэх.

#### **Онцгой байдлын газарт:**

1. Шинэ коронавирусээс урьдчилан сэргийлэх хариу арга хэмжээ авах аймгийн төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж хэрэгжүүлэх;

2. Албан хаагчдын халдвар хамгааллын хувцас хэрэглэл, бэлэн байдлыг хангаж ажиллах;

3. Шуурхай штаб байгуулах, мэргэжлийн удирдлагаар хангаж ажиллах.

#### **Хүнс хөдөө аж ахуйн газарт:**

1. Хүн амыг хүнсний хомсдол үүсэх эрсдэлээс урьдчилан сэргийлж, нөөцийн судалгаа гаргаж аймгийн Онцгой комиссыг мэдээллээр хангах;

**Хөдөлмөр, халамж үйлчилгээний газарт:**

1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ахмад настан, хүүхэд зорилтот бүлгийн иргэдийн хамгаалалд анхаарч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажиллах.

#### **Мал эмнэлгийн газарт:**

1. Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй эрчимжсэн мал аж ахуй эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгжүүдийн судалгааг нарийвчлан гаргаж, малаас хүнд халдварлах өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр ариутгал, халдваргүйтгэлийн үйл ажиллагааг зохион байгуулж ажиллах.

#### **Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газарт:**

1. Сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааг түр зогсоосонтой холбогдуулан хүүхдийг болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хүүхдийн эрхийг хамгаалах зөвлөмж боловсруулан түгээж хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэх

2. Залуучуудын хөгжлийн төв, гэр бүлд зөвлөгөө өгөх төв, түр хамгаалах байр байгууллагуудад ариутгал халдваргүйтгэл, шавжгүйтгэл хийх тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж, байгууллагаар хийлгэх.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХНАСАН